

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. МЕНЕЖМЕНТИЙН захидал	10
4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТТӨ	Татвар төлөхийн өмнөх
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СХХООАТ	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Э.НОМИНЧУЛУУН ТАНАА

2020.03.13 № 06/808
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Багануур ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Багануур ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах авлага, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Багануур ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багануур ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс, 2020 оны 3 дугаар сарын 8-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Сүлд-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Багануур ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Сүлд-Аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 05/248 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Багануур ХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь байгаль орчинд ээлтэй сөрөг нөлөөгүй, тэргүүний дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, ажиллахад оршино.

Багануур ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт
- Гадаад дотоод худалдаа
- Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Дараа тайлангийн журам / шинэчлэн баталсан /

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн боловч тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

Багануур ХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Даймонд” 5.0 программ хангамж ашигладаг байна.

Багануур ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Багануур ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 140,567.3 сая төгрөгөөс тооцон 2,811.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас тооцож материаллаг байдлын түвшинг 2,823.9 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Багануур ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,885.6 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,613.8	2,036.9	(576.9)
Авлага	9,714.6	13,313.7	3,599.1
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,609.0	8,603.3	6,994.3
Бараа материал	32,794.7	30,441.1	(2,353.6)
Үндсэн хөрөнгө	131,628.9	131,851.3	222.4
Нийт хөрөнгийн дүн	178,361.0	186,246.3	7,885.3
Богино хугацаат өр төлбөр	116,731.2	135,032.0	18,300.9
Урт хугацаат өр төлбөр	49,037.5	38,949.2	(10,088.2)
Өр төлбөрийн дүн	165,768.7	173,981.2	8,212.5
Өмч: Төрийн	1,573.1	1,573.1	-
Хувийн	524.4	524.4	-
Хуримтлагдсан ашиг	10,494.7	10,167.6	(327.1)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	178,361.0	186,246.3	7,885.3

Өмнөх оны үзүүлэлтээс дансны авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, дансны өглөгийн дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 576.9 сая төгрөгөөр буурсан нь тухайн оны авлага барагдаагүйгээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байна.

Авлага дансны үлдэгдэл 3,599.1 сая төгрөгөөр өссөн нь цахилгаан станцын авлагууд нэмэгдсэн Тухайлбал: ДЦС-3 нь тайлант оны эхэнд 312.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан оны эцэст 5,054.7 сая төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэлд 2006-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 903.6 сая төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах борлуулалтын болон бусад авлага байна. Үүнээс 2006 онд үүссэн авлага ба шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн шатанд байгаа барагдах боломжгүй, эрсдэлтэй /Энэрэлт ээж ХХК-ийн 381.1 сая, Ай Ти AUSMON ХХК-ийн 20.0 сая төгрөг/ нийт 401.1 сая төгрөгийн авлага байна. Энэ нь мөнгөн хөрөнгийн хомсдол үүсгэх, харилцагч байгууллагуудын өглөгийн үлдэгдлийг барагдуулах чадваргүй болох гэх мэт үр дагаварт хүргэж байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд Вагнер ХХК-иас хүнд даацын авто машиныг зээлээр авсан гэрээний урьдчилгаа төлбөр, Ус шүүрүүлэх байгууламжийн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Тавинлан ХХК-тай хийсэн гэрээний урьдчилгаа төлбөр, Хасу Энерги ХХК-д уулын дэд станц нүүлгэх урьдчилгаа төлбөрийн тооцоонууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 6,606.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 2,200.0 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь тоног төхөөрөмж техникийн шинэчлэл хийхэд өмнөх авто машин, техникт зориулан худалдан авсан сэлбэг хэрэгсэл нь дараагийн авто машинд таарахгүй сэлбэгийн хуримтлал үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 222.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн орлого орсонтой холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 10,104.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 152.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төмөр замын ажлын зураг, ашигт малтмалын лиценз өгөгдлийн сангийн программ хангамжууд байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 18,300.9 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан түлш, шатахуун болон сэлбэг хэрэгслийн тооцоо, 2019 оны 12 дугаар сарын цалингийн өглөг, 2018-2019 оны хооронд үүссэн татварын өглөг, 2003 онд ногдол ашиг тараах үед ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигчдэд төлөх тооцоо, мөн Эрдэнэс МГЛ ХХК-д менежментийн гэрээний дагуу зардлын 1.0 хувиар менежментийн төлбөрийг төлөх гэрээний дагуу өглөг үүсгэж зардалд бүртгэсэн өглөгүүдээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдлийн 29.5 хувийг буюу 51,891.5 сая төгрөг нь бусад богино хугацаат зээлийн өглөг байна.

Урт хугацаат зээлийн өр төлбөр нь 1998-2017 оны хооронд үүссэн 28,687.6 сая төгрөг, 2015 онд үүссэн нөхөн сэргээлтийн нөөцийн сан, бусад урт хугацаат өр төлбөр нь 2015 оны аудитын зөвлөмжөөр тэтгэврийн сан, нийгмийн хөгжлийн сангийн хуримтлалын өглөг зэргүүд байна.

Тайлант хугацаанд 69.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт дансны дүнгээр 327.1 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 396.7 сая төгрөгийн бичилт нь тайлант хугацаанд хийсэн залруулгатай холбоотой.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 33 дугаар тогтоолоор тухайн байгууллагын 2019 оны зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2018 оны гүйцэтгэл	2019 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт орлого	141,553.2	141,313.1	141,274.7	100.0	(38.4)
Цэвэр орлого/нүүрс/	138,703.5	139,104.9	138,536.5	99.6	(568.4)
Нийт зардал	140,567.3	141,172.8	141,197.3	100.0	24.5
ТТӨ ашиг	985.9	140.2	77.4	55.2	(62.8)
Цэвэр ашиг	887.3	126.2	69.7	55.2	(56.6)

/сая төгрөг/

Багануур ХК-ийн удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2019 онд 141,313.1 сая төгрөгийн орлоготой, 141,172.8 сая төгрөгийн зардалтай 140.2 сая төгрөгийн ашигтай ажиллах бизнес төлөвлөгөө баталж өгсөн байна.

Тайлант онд 141,313.1 сая төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлж 141,274.7 сая төгрөгийн орлоготой ажилласны 98.0 хувийг нүүрсний борлуулалтын орлого, 2.0 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого эзэлж байна.

2019 онд 141,172.8 сая төгрөгийн зардал гарган 140.2 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 141,197.3 сая төгрөгийн зардал гарган, 77.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хэтэрсэн, хэмнэсэн зардлуудыг дурдвал: хөдөлмөрийн зардал, шатах тослох материалын зардал, эрчим хүчний зардал дизель түлш, зээлийн хүү, цалингийн зардал, удирдлагын зардал 5,335.0 сая төгрөгөөр хэмнэсэн ба сэлбэгийн зардал 1,951.8 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 411.1 сая төгрөг, бусад зардал 3,079.2 сая төгрөг нийт 5.442.1 сая төгрөгөөр хэтэрсэн. Зардлын нийт дүнгээр 107.1 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Энэ нь 2019 онд уулын тоног төхөөрөмжүүдэд гэнэтийн төлөвлөгдөөгүй эвдрэлүүд гарснаас сэлбэгийн зардал өссөн, дугуй түрээслэгч түрээсээ зогсоосноос шинээр дугуй худалдан авсантай холбоотой зардал нэмэгдсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 3,500.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2.8 сая төгрөгийн зөрчилд 2.8 сая төгрөгийн акт тогтоож, 569.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр, 2,927.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Өмнө ажиллаж байсан гүйцэтгэх захирлын 2016 оны картын кредит тооцооны авлага 2.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр картын хуулгыг үндэслэн тайлант хугацааны зардлаар тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна .

Шийдвэрлэсэн нь:

Анхан шатны баримтгүйгээр тайлант оны зардлаар бүртгэсэн 2.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

1. Хувь хүмүүсээс авах авлага данс 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 677.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Нийт үлдэгдлийн 84.1 хувь буюу 569.6 сая төгрөгийг сэлбэг нийлүүлдэг 3 харилцагчийн тооцоо эзэлж байна. Дараа тайланг удаан хугацаанд хаадаггүй өмнөх тооцоонуудыг дуусгаагүй, дараагийн мөнгийг олгодог, цаг хугацаандаа тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар" болно, 9 дүгээр зүйлийн 9.2.1-д “Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 569.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтоов.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁷, 8.5¹⁸ дахь заалтыг зөрчин Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнээс дээш 27,260.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулахаар ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор төлөвлөж худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай " хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 заалтад заасан "8.1.1 -д заасан 50.000.001 төгрөгийн босго үнээс дээш төсөвт өртөгтэй, бараа, ажил , үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"

гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтоов.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Худалдан авах ажиллагааны тендерийн хуулийн хэрэгжилтийг хангах асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Багануур ХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, 839.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 237.1 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. Дараа тайлангаар авсан хангамжийн материалын тооцоог цаг тухайд нь хаадаггүйгээс хувь хүнээс авах авлага үүсч байгаа талаарх 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Нийт 7 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, сэлбэг материалыг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр шууд худалдан авалт хийж тендерийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа талаарх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөвлөмжийн хэрэгжилт 80.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Багануур ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд, аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Багануур ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Эрдэнэс МГЛ ХХК-ийн группийн хэмжээний Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан бүртгэлээ хөтөлж байгаа боловч тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой оршин байх, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох журам, зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Эрдэнэс МГЛ ХХК нь Группын хэмжээнд нэгдсэн программ хийлгэж ажил нь боломжгүй болсон тул манай компанийг өөрийн онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх дагалдах журам хийх, программ шинэчлэх зөвшөөрөл өгсөн.

3.2 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах авлагатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах авлага 2,110.6 сая төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэсэн заалттай нийцэхгүй үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

3.2.2. Эрсдэл:

Найдваргүй авлага нэмэгдэж алдагдал үүсэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагуудтайгаа тооцоо нийлж авлагын үлдэгдлээ баталгаажуулж байх

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 оны жилийн эцсээр байнга харилцдаг томоохон бэлтгэн нийлүүлэгч нартай тооцоо нийлсэн ба жижиг хэрэглэгч нар нь өөрийн гэсэн ажлын байргүй, хаяг тодорхойгүй зэргээс шалтгаалан тооцоо нийлээгүй байна.

3.3 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 10.7 хувийг эзэлж байна. Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлээгүй, холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 3 дахь заалт, СТОУС 16-ын 32-т "Зарим хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц, тогтмол өөрчлөлт гардаг бол тэдгээрийг жил бүр дахин үнэлэх шаардлагатай. Үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд гурваас таван жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Хөрөнгийн ашиглагдах хугацаа буруу тодорхойлогдох, зардал буруу илэрхийлэгдэх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.4 Санхүүгийн тогтвортой байдлыг хангах талаарх асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Компанийн санхүүгийн тогтвортой байдлын хувьд өөрийн хөрөнгийн оролцоо 2018 онд 7.1 хувь байсан боловч 2019 онд 6.6 хувьд хүрч, тэр хэмжээгээр өөрийн харьцаа нэмэгдэж 2019 онд нийт өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс 14 дахин их байгаа нь гадны эх үүсвэрээс хараат байдалтай байна.

3.4.2. Эрсдэл:

Өр төлбөрийн хэмжээ нэмэгдэх, төлбөрийн чадвар алдагдах;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Санхүү төлбөрийн чадварыг нэмэгдүүлэхийн тулд байгууллагын өнөөгийн байдал хэтийн төлөвийг тодорхойлж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөрийн хэмжээ өөрийн хөрөнгөөс 14 дахин их болсон байна. Уурхай өртгөөс доогуур үнээр нүүрсээ борлуулж байгаагаас сүүлийн жилүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалт, мөнгөн урсгалын дутагдлыг зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэж ирлээ. Үүнээс шалтгаалан өр төлбөрийн хэмжээ жил бүр нэмэгдэж байна. Энэ талаар Толгой компани, салбарын яам, ЭХЗХ-нд албан бичгээр мэдэгдсэн. Үүний дүнд ЭХЗХ-ноос нүүрсний үнийг 2000 төгрөгөөр нэмэгдүүлж өгсөн.

3.5 Төлбөрийн чадварын талаарх асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Богино хугацаат өр төлбөрүүд нь авлагын дүнгээс дунджаар 10 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдаж төлбөрийн чадварт муугаар нөлөөлж байна.

3.5.2. Эрсдэл:

Төлбөрийн чадваргүй болох, хэвийн үйл ажиллагаа алдагдах;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн бодлого, ирээдүйн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө хүч нөөц бололцоог нэмэгдүүлэхэд байгууллагын зүгээс тусгайлсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 онд авлагын хэмжээ нийт өр төлбөрөөс 10 дахин бага болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор компанийн төлбөрийн чадвар эрс муудаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсгэх хэмжээнд хүрээд байна. 2018 онд бидний зүгээс толгой компанитай хамтран МУ-ын Засгийн газарт уурхайн нөхцөл байдал хүндэрч байгаа талаар танилцуулсны дүнд ЗГ-ын 132 тоот тогтоол гарсан бөгөөд тогтоолын хүрээнд Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс ТТ ХХК-уудаас хөнгөлөлттэй зээл олгосон. Гэвч тус ажил нь өрийг өрөөр барагдуулах ажил болсон нь дорвитой хөнгөлөлт болж чадаагүй. Мөн урт хугацаат өр төлбөрийг тэглэх, компанид оруулсан хөрөнгө оруулалт хэлбэрээр бүртгэх ажлуудыг толгой компанийн хэмжээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

3.6 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.6 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Сэлбэг хэрэгслийг түүвэрлэн үзэхэд өмнөх онд үлдэгдэл нөөцтэй байгаа боловч тайлант хугацаанд дахин 817.1 сая төгрөгийн сэлбэгийг худалдан авч огт ашиглаагүй,

хэрэгцээгүй сэлбэг материалын нөөц нэмэгдэж хөрөнгийг үнэгүйдүүлж байна. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Хэрэгцээгүй хөрөнгө нэмэгдэж хөрөнгийн үнэ цэнэ буурах;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид сэлбэг хэрэгслийн шаардлагатай нөөцийн бүртгэлийг гаргаж, батлуулж мөрдөж ажиллах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төлөвлөгөөт засвар хийгдээгүй учраас худалдан авсан сэлбэг хуримтлагдах шалтгаан болдог. Ослын аюулгүйн нөөц бүрдүүлэхтэй холбоотой зайлшгүй байх шаардлагатай сэлбэг хэрэгсэл байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,613,810,300.27	2,036,934,401.99
1.1.2	Дансны авлага	8,910,237,907.19	12,756,011,354.94
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	780,740,598.11	531,044,878.07
1.1.4	Бусад авлага	23,600,000.00	26,700,000.00
1.1.5	Бараа материал	32,794,739,265.96	30,441,076,183.52
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,609,047,077.47	8,603,337,204.15
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	46,732,175,149.00	54,395,104,022.67
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	101,280,282,796.05	101,118,629,971.33
1.2.2	Биет бус хөрөнгө	4,868,996,634.21	4,766,625,348.72
1.2.3	Уул уурхайн хөрөнгө /УУ Хөгжүүлэлт, Хөрс хуулалт/	23,274,763,144.40	24,201,882,420.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	999,767,331.34	999,767,331.34
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,204,812,387.00	764,393,387.00
1.2.6	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	131,628,622,293.00	131,851,298,458.79
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	178,360,797,442.00	186,246,402,481.46
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	37,832,936,064.58	51,378,313,611.13
2.1.1.2	Цалингийн өглөг	2,751,587,225.00	1,551,511,014.35
2.1.1.3	Татварын өр	19,161,198,817.82	24,040,668,565.45
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,868,251,340.55	3,951,779,921.79
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	52,413,392,192.29	51,891,576,198.24
2.1.1.6	Хүүний өглөг	74,992,525.75	460,374,348.92
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	12,971,933.50	12,971,933.50
2.1.1.8	Банкны богино хугацаат өр төлбөр	2,615,874,719.07	1,744,854,966.01
2.1.1.9	Богино хугацаат өр төлбөрийн дүн	116,731,204,818.56	135,032,050,559.39
2.1.1.10	Урт хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Урт хугацаат зээл	35,811,641,302.89	28,687,562,419.95
2.1.1.12	Нөөц өр төлбөр	1,167,266,443.09	1,167,266,443.09
2.1.1.13	Бусад урт хугацаат өр төлбөр	12,058,585,989.75	9,094,470,397.46
2.1.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	49,037,493,735.73	38,949,299,260.50
2.2	Өр төлбөрийн нийт дүн	165,768,698,554.29	173,981,349,819.89
2.3	Эздийн өмч	2,097,436,000.00	2,097,436,000.00
2.3.1	Өмч: Төрийн	1,573,077,000.00	1,573,077,000.00
2.3.2	Хувийн	524,359,000.00	524,359,000.00
2.3.3	Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.6	Хуримтлагдсан ашиг	10,494,662,887.71	10,167,616,661.57
2.3.7	Эздийн өмчийн дүн	12,592,098,887.71	12,265,052,661.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	178,360,797,442.00	186,246,402,481.46

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	138,703,519,714.83	138,536,533,328.54
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	123,535,157,437.06	131,526,746,086.30
3	Нийт ашиг (алдагдал)	15,168,362,277.77	7,009,787,242.24
4	Түрээсийн орлого	76,029,927.24	54,395,427.24
5	Хүүний орлого	18,121,307.73	23,308,226.49
6	Ногдол ашгийн орлого	57,011,717.70	
7	Бусад орлого	2,695,546,217.40	2,651,665,660.17
8	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
9	Ерөнхий ба удирдлагын зардал	16,788,176,740.65	9,069,398,278.78
10	Санхүүгийн зардал		
11	Бусад зардал	224,980,225.45	592,055,754.16
12	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(15,936,011.13)	(294,073.74)
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
14	Бусад ашиг (алдагдал)		
15	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	928,966,752.91	77,408,449.46
16	Орлогын татварын зардал	98,597,847.06	7,740,844.95
17	Татвар дараах ашиг (алдагдал)	830,368,905.85	69,667,604.51
18	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
19	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	830,368,905.85	69,667,604.51
20	Бусад дэлгэрэнгүй орлого	-	
20.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
20.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
20.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	830,368,905.85	69,667,604.51
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	149,560,674,882.44	129,020,657,650.61
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	149,219,928,969.94	128,679,217,785.61
1.1.2	Буцаан авсан албан татвар	327,099,320.45	300,542,063.91
1.1.3	Бусад мөнгөн орлого	13,646,592.05	40,897,801.79
1.2	Мөнгөн зарлагын дүн	119,117,687,023.64	118,567,530,323.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	28,400,940,737.92	31,532,561,664.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,254,173,451.00	6,750,447,898.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	65,745,854,623.04	42,817,530,349.92
1.2.4	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	155,600.00	23,632,819,675.49
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	3,711,356,833.43	963,223,160.80
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	9,784,813,921.00	9,962,857,878.13
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	-	109,287,000.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	2,220,391,857.25	2,798,802,697.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	30,442,987,858.80	10,453,127,327.52
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	18,121,307.73	23,308,226.49
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.2	Хүлээн авсан ноогдол ашиг		
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	18,121,307.73	23,308,226.49
2.2	Мөнгөн зарлагын дүн	21,647,933,048.21	10,256,297,973.70
2.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	21,647,933,048.21	10,104,021,483.70
2.2.3	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		152,276,490.00
2.2.4	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,629,811,740.48)	(10,232,989,747.21)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	10,062,458,764.73	4,800,763,651.46
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,059,408,625.00	4,800,000,000.00
3.1.2	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	3,050,139.73	763,651.46
3.2	Мөнгөн зарлагын дүн	17,519,156,753.89	5,597,777,076.37
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	17,515,979,795.77	5,597,621,896.27
3.2.2	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	3,176,958.12	155,180.10
3.2.3	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,456,697,989.16)	(797,013,424.91)
3.3.1	Валютын ханшийн зөрүү		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,356,478,129.16	(576,875,845.30)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,544,823,782.31	2,613,810,300.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,613,810,300.27	2,036,934,401.99

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,097,436,000.00	49,028,562,608.57	10,569,225,410.76	61,695,224,019.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,097,436,000.00	49,028,562,608.57	10,569,225,410.76	61,695,224,019.33
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(49,028,562,608.57)		(49,028,562,608.57)
6	Өмчид гарсан өөрчлөлт			(961,943,146.60)	(961,943,146.60)
7	Тайлант үеийн үр дүн			887,380,623.55	887,380,623.55
9	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,097,436,000.00	-	10,494,662,887.71	12,592,098,887.71
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,097,436,000.00	-	10,494,662,887.71	12,592,098,887.71
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			(396,713,830.65)	(396,713,830.65)
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
16	Тайлант үеийн үр дүн			69,667,604.51	69,667,604.51
17	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,097,436,000.00	-	10,167,616,661.57	12,265,052,661.57

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.13	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	САГ-2020/102/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Багануур ХК		сая төгрөгөөр		

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	
	1	4	5	9	
1	Эрдэнэс МГЛ ХХК-ийн группийн хэмжээний Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан бүртгэлээ хөтөлж байгаа боловч тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог бүрэн нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой оршин байх, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	
2	2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах авлага 2,110.6 сая төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэсэн заалттай нийцэхгүй үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна	2,110.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч Авлагын нягтлан бодогч	

3	<p>Тус байгууллагын санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө нийт үндсэн хөрөнгийн 10.7 %-ийг эзэлж байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 3 дахь заалт, СТОУС 16-ын 32-т “Зарим хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц, тогтмол өөрчлөлт гардаг бол тэдгээрийг жил бүр дахин үнэлэх шаардлагатай. Үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд гурваас таван жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	П. Эрдэнээ
4	<p>Компанийн санхүүгийн тогтвортой байдлын хувьд өөрийн хөрөнгийн оролцоо 2018 онд 7.1 хувь байсан боловч 2019 онд 6.6 хувьд хүрч, тэр хэмжээгээр өрийн харьцаа нэмэгдэж 2019 онд нийт өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс 14 дахин их байгаа нь гадны эх үүсвэрээс хараат байдалтай байна.</p>		Зөвлөмж өгөх	СХОЭЗахирал СЭЗБХэлтэсийн дарга	Д.Ганзориг Д.Болд
5	<p>Богино хугацаат өр төлбөрүүд нь авлагын дүнгээс дунджаар 10 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдаж төлбөрийн чадварт муугаар нөлөөлж байна.</p>		Зөвлөмж өгөх	СХОЭЗахирал СЭЗБХэлтэсийн дарга	Д.Ганзориг Д.Болд
6	<p>Хувь хүмүүсээс авах авлага дансанд 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 677.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Нийт үлдэгдлийн 84.1 хувь буюу 569.6 сая төгрөгийг сэлбэг нийлүүлдэг 3 харилцагчын тооцоо эзэлж байгаа бөгөөд дараа тайланг удаан хугацаанд хаадаггүй өмнөх тооцоонуудыг дуусгаагүй байхад дараагийн мөнгийг олгодог, цаг хугацаандаа тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй нь НББ-ийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар" болно, 9.2.1-д "Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна</p>	569.6	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч Мөнгөн хөрөнгө нягтлан бодогч	П. Эрдэнээ, Б.Балжинням

7	<p>Өмнөх онд үлдэгдэл нөөцтэй байгаа боловч тайлант хугацаанд худалдан авч огт ашиглаагүй сэлбэг хэрэгслийг түүвэрлэн үзэхэд 817.1 сая төгрөгийн сэлбэгийг худалдан авсан боловч огт ашиглагдаагүй байгаа нь хэрэгцээгүй сэлбэг материалын нөөц нэмэгдэж хөрөнгийг үнэгүйдүүлж байгаа нь үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна</p>	817.1	Зөвлөмж өгөх	Худалдаа хангамж хариуцсан хэлтэсийн дарга	С.Батхишиг
8	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.417, 8.518 дахь заалтыг зөрчин Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнээс дээш байхад 27,260.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулахаар төлөвлөж худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай " хуулийн 8-р зүйлийн 8.2 заалтад заасан "8.1.1 -д заасан 50.000.001 төгрөгийн босго үнээс дээш төсөвт өртөгтэй, бараа, ажил , үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, Иж бүрэн, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>		Албан шаардлага өгөх	Худалдаа хангамж хариуцсан хэлтэсийн дарга	С.Батхишиг
9	<p>Өмнө ажиллаж байсан гүйцэтгэх захиралын 2016 оны картын кредит тооцооны авлага 2.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр картын хуулгыг үндэслэн тайлант хугацааны зардлаар тайлагнасан нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна</p>	2.8	Акт тогтоов	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	Э.Номинчулуун, П. Эрдэнээ
Дүн		3,500.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/63

Улаанбаатар хот

СЯТ- 0020/102/СЯТ-Т04Г

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнө ажиллаж байсан гүйцэтгэх захирлын 2016 оны картын кредит тооцооны авлага 2.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр картын хуулгыг үндэслэн тайлант хугацааны зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д ...заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүйгээр тайлант хугацааны зардлаар бүртгэсэн 2,800,000.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун, ерөнхий нягтлан бодогч П.Эрдэнэ нарт даалгав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Х. Б.ЭРДЭНЭЗУЛ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.ГҮНДБАЯР

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Э.НОМИНЧУЛУУН

НЯГТЛАН БОДОГЧ
П.ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харьцуцагч албан тушаалтныг харьцуулага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/140

Улаанбаатар хот

СРГ- 2020/102/СТА ТӨЧГ
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүмүүсээс авах авлага дансанд 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 677.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Нийт үлдэгдлийн 84.1 хувь буюу 569.6 сая төгрөгийг сэлбэг нийлүүлдэг 3 харилцагчын тооцоо эзэлж байгаа бөгөөд дараа тайланг удаан хугацаанд хаадаггүй өмнөх тооцоонуудыг дуусгаагүй байхад дараагийн мөнгийг олгодог, цаг хугацаандаа тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулдаггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар" болно, 9 дүгээр зүйлийн 9.2.1-д "Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах", 13.1, 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20.2.5, 20.2.6-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хувь хүмүүсээс авах авлагын тооцоог нийлж, үлдэгдэл тооцоог тулган баталгаажуулах, гэрээ байгуулж гэрээг дүгнэх, тайлант ондоо тооцоог дуусгах, зөрчлийг таслан зогсоох.

Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун, ерөнхий нягтлан бодогч П.Эрдэнээ нарт даалгав.

ТОГТООСОН:	АЛБАН ШААРДЛАГА	ЗӨВШӨӨРСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ АУДИТОР <i>Б.Эрдэнэзул</i> ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ: СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ <i>Ч.Гүндбаяр</i>	БАГАНУУР ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ <i>Э.НОМИНЧУЛУУН</i>	

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/141

Улаанбаатар хот

СЯГ-2020/102/СТА-ТӨСГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Багануур ХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁷, 8.5¹⁸ дахь заалтыг зөрчин Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнээс дээш байхад 27,260.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулахаар төлөвлөж худалдан авалтыг шууд гэрээгээр хийсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг таслан зогсоох.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун, ерөнхий нягтлан бодогч П.Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ч.ГҮНДБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

БАГАНУУР ХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Э.НОМИНЧУЛУУН

НЯГТЛАН БОДОГЧ
П.ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.